


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

06.29 - 07.03



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс дээд түвшиндээ хүрсэн бол S&P 500 индекс 06-р сарын 10-ны өдрөөс хойших хамгийн өндөр түвшиндээ хүрлээ. S&P 500 индексийн сагсанд багтах Netflix болон видео тоглоом үйлдвэрлэгч компаниудын хувьцаа өсөлттэй байсантай холбоотой харилцаа холбооны салбар мөн үл хөдлөх хөрөнгийн салбар хамгийн их өсөлттэй байсан бол санхүүгийн болон эрчим хүчний салбар уналттай байлаа. Баасан гарагт АНУ-ын тусгаар тогтнолын өдөртэй холбоотойгоор зах зээл хаалттай байлаа.

АНУ-ын Өмнөд ба Баруун өмнөд хэсэгт коронавирус дахин сэргэж байгаатай холбоотой зарим мужийн захирагчид эдийн засгаа дахин нээх шийдвэрээ буцааж эсвэл түр зогсоохоо мэдэгдэв. Гэхдээ улсын хэмжээнд вирусийн тохиолдлын өсөлт долоо хоногийн эхээр удааширсан ба Лхагва гарагт вакцин боловсруулахтай холбоотой эерэг мэдээлэл гарснаар зах зээл өсөлт үзүүлээ.

Европ: Коронавирусийн эсрэг вакцинтай холбоотой эерэг мэдээлэл болон эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаатай холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Европын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг STOXX Europe 600 индекс 2.11%-аар өсөж хаагдсан бол DAX индекс 3.33%-аар, CAC-40 индекс 2.41%-аар, FTSE MIB индекс 3.11%-аар, FTSE 100 индекс 0.58% -аар тус тус өссөн байна.

Хөл хорионы арга хэмжээнүүд цуцлагдаж дэлгүүр зэрэг зарим бизнесүүд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбоотой 06-р сарын эдийн засгийн үзүүлэлтүүд Евро бүсийн эдийн засаг сэргэж эхэлж байгааг илтгэж байна. ХБНГУ-ын жижиглэнгийн худалдааны хэмжээ 13.9%-аар өссөн нь шинжээчдийн таамаглаж байсан 2.8%-аас өндөр үзүүлэлт боллоо. Жижиглэнгийн худалдааны хэмжээ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 3.8%-аар өссөн ба эдийн засагчид 3.5%-аар буурна гэж таамаглаж байжээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Nikkei 225 индекс 0.91%-аар буурсан ба зах зээлийг ерөнхийд нь илтгэгч TOPIX индексүүд мөн уналттай хаагдсан байна. 05-р сарын сүүлээр болон 06-р сарын эхээр явагдсан хөрөнгийн зах зээлийн өсөлтөөс хойш сүүлийн хэдэн долоо хоногийн туршид зах зээл зогсонги байдалд орж, Nikkei индекс 06-р сарын 08-ны өдрийн дээд түвшнээсээ 4.7%-аар буураад байна.

Японы төв банкны улирал тутмын судалгааны дүнгээс харахад итгэлцлийн түвшин цар тахлын улмаас сүүлийн саруудад огцом унасан байдалтай байна.

БНХАУ: Энэ жилийн эхний улирлын эдийн засгийн түүхэн уналтын дараа БНХАУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд эрчимтэй сэргэж эхэлснээр БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Пүрэв гарагт CSI 300 индекс 2018 оны 01-р сарын 26-ны өдрөөс хойших хамгийн өндөр түвшиндээ хүрч хаагдсан бол Shanghai Composite индекс 01-р сараас хойших дээд түвшиндээ хүрч хаагдлаа.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,497.72	2.09% ▲
Dow Jones	АНУ	25,827.36	3.25% ▲
S&P 500	АНУ	3,130.01	4.02% ▲
Nasdaq	АНУ	10,207.63	4.62% ▲
S&P/TSX	Канад	15,596.75	2.68% ▲
FTSE 100	Их Британи	6,157.30	-0.03% ▼
S&P/ASX 200	Австрали	6,057.90	2.60% ▲
Nikkei 225	Япон	22,306.48	-0.91% ▼
Hang Seng	Хонг Конг	25,373.12	3.35% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.63
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.43
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.89
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.33
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.70
DBM' 2023	USD	7.250%	96.38
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	87.83

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.163	-0.09 ▼
Libor 3M	0.276	-0.10 ▼
Libor 6M	0.366	0.01 ▲
Libor 1YR	0.506	-0.11 ▼
US 2YR Bond	0.157	-0.07 ▼
US 3YR Bond	0.186	0.00 ▲
US 5YR Bond	0.302	0.00 ▲
US 10YR Bond	0.686	0.07 ▲

Валютын ханш	2020.07.03	Өөрчлөлт
USD	2,826.14	0.18% ▲
CNY	399.92	0.34% ▲
EUR	3,175.17	0.23% ▲
RUB	40.07	-1.74% ▼
KRW	2.36	0.43% ▲
JPY	26.29	-0.34% ▼
CAD	2,084.48	0.90% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,772.05	0.04% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	18.02	1.18% ▲
Зэс	USD/lb.	273.00	1.90% ▲
Нүүрс	USD/MT	54.27	-0.48% ▼
WTI газрын тос	USD/bbl.	40.44	5.07% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.80	4.34% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.75	16.67% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.V	3.30%
Бодлогын хүү	2020.V	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.V	8.93%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.V	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.V	4.48%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.V	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.V	10.41%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 43 компанийн 677.3 сая төгрөгийн 2,972,367 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Шивээ овоо” /SHV/ компанийн хувьцаа 30.59%-аар буюу хамгийн ихээр өсөж 2,220.00 төгрөг хүрч хаагдсан бол “Тээвэр дархан” /TEE/ компанийн хувьцаа 14.47%-аар буурч 6,500.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 2.2 сая төгрөгийн 22 ширхэг бонд арилжаалагдав.

07-р сарын 03-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,507.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,497.72 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.09%-аар өссөн байна.



Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	10	987,900.00	98,700.00	99,000.00	52	17%
2	LNBO-BD-19/06/21-C0008-17	10	998,000.00	98,000.00	100,000.00	52	17%
3	LNBO-BD-19/06/21-C0008-17	1	100,800.00	100,800.00	100,800.00	52	17%
4	LNBO-BD-19/06/21-C0008-17	1	99,980.00	99,980.00	99,980.00	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	1,342.52	
Зах зээлийн үнэлгээ	2,506,998.35	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,497.72	2.09% ▲
MSE I индекс	8,021.03	0.40% ▲
MSE II индекс	7,568.59	3.91% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Махимпекс	190,047	459,915,030
БиДиСек	460,000	455,400,000
Баянгол зочид буудал	6,056	181,352,000
Бодь даатгал	386,709	43,190,901.3
АПУ	60,644	32,857,586.49

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Шивээ овоо	2,220.00	30.59% ▲
Ариг гал	3,000.00	15.38% ▲
БиДиСек	990.00	14.98% ▲
Монгол савхи	517.00	14.89% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	660.00	11.86% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Тээвэр дархан	6,500.00	-14.47% ▼
Авто импекс	1,125.00	-13.46% ▼
Адуун чулуун	900.00	-11.76% ▼
Баянгол зочид буудал	26,000.00	-11.56% ▼
Бодь даатгал	103.95	-5.89% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	1,734,276,068.80
Ард секюритиз	719,596,326.96
Стандарт инвестмент	37,303,901.75
Бумбат-Алтай	27,267,558.10
Ти Ди Би Капитал	27,036,400.21

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	542.66	577,489
Таван толгой	5,525,00	290,975
МИК холдинг	12,990,00	269,014
Инвексор ББСБ	2,514,00	180,324
Говь	197.67	154,205

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 06-р сарын 29-ний өдрийн 689 тоот тогтоолоор “Сүү” ХК-ийн шинээр нэмж гаргаж байгаа 85,589,000 ширхэг энгийн хувьцааг бүртгэж, тус компанийн нийт гаргасан хувьцааг 429,589,000 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн байна. Шинээр нэмж гаргасан хувьцааны нэгж үнийг 218 төгрөгөөр тогтоож 77,030,100 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 8,558,900 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ ХК хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашгаа хуваариллаа.

“Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн эчнээ санал хураалтаар компанийн 2019 оны цэвэр ашгийн 29.4% буюу нийт 1 тэрбум төгрөгийг, хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашгаар хуваарилах шийдвэр гаргаж, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2020 оны 04-р сарын 07-ны өдрөөр тогтоосон билээ.

Уг шийдвэрийн дагуу тухайн бүртгэлийн өдрөөр хувьцаа эзэмшиж байсан нийт 4,234 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2020 оны 06-р сарын 30-ны өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн дансанд шилжүүлжээ.

Эх сурвалж: ТиДиБи Капитал ҮЦК

“Ард даатгал” /MSE: AIC/ ХК шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаа тухай мэдээлэл

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 443-р тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 3.2.2.11 дэх заалт болох “Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох үйл ажиллагааг нийтэд ил тод байлгана” гэсэн заалтын хүрээнд “Ард даатгал” /MSE: AIC/ ХК-ийн зүгээс шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаа талаараа СЗХ болон олон нийтэд зохих мэдээллийг хүргүүлжээ.

Тус мэдэгдэлд дурдсанаар 2020 оны 06-р сарын 25-ны байдлаар “Ард даатгал” /MSE: AIC/ ХК нь “ЭПП” ХХК, “Хаппи веритас” ХХК, “МИАТ” ХХК зэрэг компаниудтай иргэний хэргийн анхан шатны шүүх болон нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэгчээр оролцож байгаагаа мэдэгдлээ. Мөн “ШУБХ” ХХК болон иргэн “Н” нарт холбогдох иргэний хэргийн анхан шатны шүүхэд хариуцагчаар оролцож байна.

Дээрх маргаанууд нь шүүхийн шатанд хянан хэлэлцэгдэж байгаа буюу шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны мэдэгдэл.

Компанийн тухай хуульд Хувьцаат Компанийн ТУЗ хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу жил бүрийн 05-р сарын 01-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулахаар заасан.

Гэвч нэр бүхий 63 хувьцаат компани нь 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуралдуулаагүй байгаа тул эдгээр нэр бүхий 63 ХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 59.5-д зааснаар “Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно” гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг ээлжит бусаар зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болсныг мэдээллээ. Нэр бүхий 63 компанид “Автозам” ХК, “Дорнод” ХК, “Борнуур” ХК зэрэг компаниуд багтсан байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Дархан нэхий” /MSE: NEH/ ХК хувьцаа эзэмшигчдийн хурлаараа 1:1000 харьцаатайгаар хувьцааг хуваах шийдвэр гаргалаа.

“Дархан нэхий” /MSE: NEH/ ХК нь Монголын хөрөнгийн зах зээл дээр нэгж хувьцаа нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 1,105,475 ширхэг хувьцааг бүртгүүлсэн байдаг бөгөөд 2020 оны 01-р сарын 30-ны өдөр болсон компанийн ТУЗ-ын хурлын шийдвэрийн дагуу нэгж хувьцаагаа 1000 хуваах шийдвэрийг баталсан байна. Ингэснээр тус компани нэгж хувьцаа нь 0.1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 1,105,479,000 ширхэг хувьцаатай болох юм.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монгол Улсын банкны салбарын нөлөө бүхий банкууд болох Худалдаа, хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкууд нэгдэх шийдвэр гаргалаа. Худалдаа, хөгжлийн банк нь банкны системийн нийт активын 19.4%-ийг эзэлдэг, 1900 орчим ажилтан, 58 салбар нэгжтэй, Улаанбаатар хотын банк нь банкны системийн нийт активын 3.8%, 400 орчим ажилтан, 33 салбар нэгжтэй банкууд юм.

Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд нийцүүлэн Монголбанкнаас 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр банкныг өөрчлөн байгуулах замаар нэгтгэх зөвшөөрлийг олгосон бөгөөд банкуудын нэгдэл нь банкны үйл ажиллагаа өргөжих, зах зээлд эзлэх хувь хэмжээ болон харилцагчдад хүрэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар болон санхүүгийн тоон үзүүлэлтүүд сайжрах зэрэг давуу талтай юм.

Улаанбаатар хотын банкны салбар, тооцооны төвүүд нь Худалдаа, хөгжлийн банканд нэгдэн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэн ажиллаж байна.

Олон улсын практикт банк, санхүүгийн байгууллагын нэгдэл үүсэх нь хэвийн үйл явдал бөгөөд Худалдаа, хөгжлийн банкны үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгааг Монголбанкны зүгээс мэдэгдэж байна.

Эх сурвалж: Монголбанк



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

2019 оны 10-р сард Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх, холбогдох техникийн дутагдлыг арилгах чиглэлээр ФАТФ болон Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй хамтран ажиллах улс төрийн өндөр түвшний үүрэг амлалтыг өгсөн. Энэ хүрээнд ФАТФ-ын 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн онлайн хурлаар Монгол Улсыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хангалттай биелүүлсэн гэж дүгнэлээ. Түүнчлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх, цаашид хэрэгжилтийг тогтвортой хангахын тулд улс төрөөс шаардагдах хүчин чармайлт байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор газар дээрх хяналт шалгалт хийх шийдвэрийг гаргав.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ


Оны эхнээс 06-р сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд Монгол Улс нийт 8.5 сая тонн чулуун нүүрсийг 677.7 сая ам.доллароор экспортолсон байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.1-2.2 дахин бага байна. Гол хэрэглэгч зах зээл болох БНХАУ-ын коксжих нүүрсний импорт тавдугаар сард 4.79 сая тонн болж, жилийн өмнөхөөс 19 хувиар, сарын өмнөхөөс 24 хувиар буурсан байна. Импортоор худалдаж авсан коксжих нүүрсний үнэ тонн тутамдаа дунджаар 117.9 ам.доллар болж, жилийн өмнөхөөс 10 ам.доллар, сарын өмнөхөөс 16 ам.доллароор буурсан талаар "Sxcoal.com" мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Монгол улсын нүүрсний экспорт 1, 2-р саруудад бага байдаг ч 2020 оны эхний 5 сард Ковид-19 вирусын тархалттай холбоотойгоор огцом буурсан ба олон улсын зах зээлд 2018 оны 6-р сараас эхлэн нүүрсний үнэ буурч эхэлсэн бол Монгол улсын экспортын үнэ харьцангуй тогтвортой байна.

АМГТГ-ны статистикийн мэдээллээс харахад 2019 оны эхний 5 сарын гүйцэтгэлтэй харьцуулахад 2020 оны эхний 5 сард Хөрс хуулалт 25.7%-аар, Олборлолт 53.6%-аар, Борлуулалт 53.3%-аар, Экспорт 66.2%-аар буурсан үзүүлэлттэй байна.

ҮСХ-ны гадаад худалдааны статистикаас харахад 2019 оны эхний 5 сарын гүйцэтгэлтэй харьцуулахад 2020 оны эхний 5 сард Нүүрсний экспорт тоо хэмжээ 15.1 сая тонн байснаас 6.3 сая тонн болж 58.3%-аар буурсан бол нүүрсний экспортын үнийн дүн 1.3 тэрбум ам.доллар байснаас 513.3 сая ам.доллар болж 59.7%-аар буурсан үзүүлэлттэй байна.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.